



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/394

Улаанбаатар хот

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг элсүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 79, 80 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоог Багахангай, Багануур, Баянзүрх, Налайх дүүрэгт тус бүр 5, Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт тус бүр 6, Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт тус бүр 7, Чингэлтэй дүүрэгт 8, Нийслэлийн хэмжээнд нийт 54 иргэнийг элсүүллсүгэй.

2. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын цэргийн албаны бэлтгэл сургалтыг 2019 оны II улиралд зохион байгуулсугай.

3. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг журмын дагуу элсүүлэн, сургалтуудыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж, шаардлагатай хувцас, эд хэрэглэлийн зардлыг гаргахыг дүүргүүдийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

111070301996